



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 25 өдөр

Дугаар А/584

Арвайхээр

Цэцэрлэг шинээр байгуулах тухай

Боловсролын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1.3, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газрын 2020 оны 275 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлтийн дагуу Хужирт суманд шинээр баригдсан 50 хүүхдийн хүчин чадалтай цэцэрлэгийг 4 дүгээр цэцэрлэгээр үүсгэн байгуулсугай.

2.Хужирт сумын 4 дүгээр цэцэрлэгийн үйл ажиллагааны дүрэм, бүтэц, зохион байгуулалтыг 2021 оны 01 дүгээр сарын 15-ны дотор хийж, сургалтын үйл ажиллагааг зохион байгуулах бэлтгэл ажлыг ханган, тусгай зөвшөөрөл авахад шаардагдах материалыг хуулийн дагуу бүрдүүлэхийг аймгийн Засаг даргын дэргэдэх Боловсрол, соёл, урлагийн газар (Ж.Пүрэвсүрэн), Хужирт сумын Засаг дарга (Т.Баярмөнх)-д тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101306